


ВАНУАТУГААС мэндчилж байна!

Вануату бол Номхон далайд орших халуун орны арал юм. 300 мянга гаруй хүн тэнд амьдардаг!



ӨНГӨЛӨГ МӨНГӨ

Вануату нь арлын амьдралыг болон тэнд амьдардаг амьтан ургамлыг дүрсэлсэн тод өнгийн мөнгөтэй.



ҮЙЛ
АЖИЛЛАГАА

ЦЭЦГЭН ТИТЭМ

Вануатугийн хүмүүс баяр ёслолоор олон өнгийн цэцгэн титэм зүүдэг.

Өнгийн цаасыг цэцгэн хэлбэрээр хайчил. Цэцэг бүрийн голд жижиг нүх гарга. Толгойгоо тойруулаад боох хангалттай урт **уяа** хайчил. Уяандаа цаасан цэцгүүдээ хэлх. Дараа нь уяаныхаа хоёр үзүүрийг холбож уя. Титмээ зүүхэд бэлэн боллоо!



Мормоны Ном 2004 онд бислам хэлээр орчуулагдсан. Түүнээс хойш 8000 гаруй хүн Вануату дахь Сүмд нэгджээ!

МОРМОНЫ НОМ

2017 оны 8-р сард Сүмийн гишүүд Вануатуд ахлагч Гари Э.Стивэнсон ахын удирдсан галын дэргэдэхэд оролцжээ.



ХАЛУУН ОРНЫ АРАЛ

Вануату нь үзэсгэлэнт далайн эрэг, тунгалаг цэнхэр усаараа алдартай. Зарим далайн эрэг нь бүр хар элстэй!



ХЭЛ

Албан ёсны хэл нь бислам, англи, франц юм. Бараг бүх хүн нь бисламаар ярьдаг!



ЖОР

Кокостой бялуу

Кокостой бялуу нь Вануатуд их алдартай. Энэ жорыг туршаад үзээрэй!

1. Саванд $\frac{1}{2}$ аяга элсэн чихэр, $\frac{1}{4}$ аяга хайлуулсан цөцгийн тос хийж сайтар хутгана.
2. 2 өндөг нэмж хийгээд хутгана.
3. Дээрээс нь $\frac{1}{2}$ аяга гурил, 1 аяга үрсэн кокос, мөн 1 цайны халбага хөөлгөгч нунтаг хийж холино.
4. Тосолсон дугуй хэлбэртэй бялууны саванд хийж 150° хэмд 20 минут жигнэнэ.

Томчуудаас тусламж аваарай!

Танкюу.



Энэ нь бисламаар "баярлалаа" гэсэн үг.